

5 ДУГААР ХАВСРАЛТ

“Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал” батлах тухай

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 7.2 дахь заалт болон 14.2.5-д заасан даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцоход энэхүү аргачлалыг мөрдлөг болгоно.

ХОЁР. ДААТГАЛЫН ХЭМЖЭЭ

2.1. Даатгалын хэмжээ гэж даатгалын хураамж тооцох, эсвэл даатгалын тохиолдол болоход даатгагчаас даатгуулагчид төлөх нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход үндэслэл болгож байгаа зүйлийн бодит үнэ цэнийг хэлнэ.

2.2. Даатгалын хэмжээг Монгол Улсын Иргэний хуулийн 438.1 дүгээр заалтын дагуу даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцож тогтооно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

3.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

3.1.1. Даатгалын цэвэр хураамж;

3.1.2. Даатгалын нэмэлт хураамж.

3.2. Даатгалын цэвэр хураамжаар даатгалын хохирлыг нөхөн төлөхөд зарцуулах нөөцийн санг бүрдүүлнэ.

3.3. Даатгалын нэмэлт хураамжид даатгалын үндсэн үйл ажиллагааны зардлууд болон даатгагчийн хариуцах даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэл, татвар хураамжууд багтана.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ

4.1. Даатгалын хураамжийн хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтлана:

4.1.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагчийн эрх, ашигт нийцсэн байх;

4.1.2. Хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцээтэй байх;

4.1.3. Даатгалын үйл ажиллагаа явуулахад даатгагчийн зардлыг нөхөхүйц байх;

4.1.4. Даатгалын хураамжийн хэмжээ нь харьцангуй тогтвортой байх.

4.1.5. Даатгалын бүтээгдэхүүний эрсдэлд нөлөөлөх томоохон хүчин зүйлсийг тусгасан байх;

4.2. Даатгалын хураамжийн хэмжээг дараах байдлаар тооцно:

4.2.1. Даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах мэдээллийг даатгагч, даатгалын салбарын болон бусад улсын ижил төстэй мэдээлэлд үндэслэн боловсруулна;

4.2.2. Даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах оновчтой актуар аргачлалуудыг сонгоно;

4.2.3. Энэ аргачлалын 4.2.1-д заасан мэдээллийг үндэслэн хураамжийн хувь хэмжээг тогтооно;

4.2.4. Нэмэлт хураамжид даатгагчийн үйл ажиллагааны зардал болон ашгийг оруулан тооцно;

4.3. Урт хугацааны даатгалын цэвэр хураамжийг тооцоход энэ аргачлалын 4.2-т зааснаас гадна дараах зүйлсийг үндэслэн тооцно.

4.3.1. Хүн амын насжилтын хүснэгт;

4.3.2. Хүн амын нас баралтын түвшин;

4.3.3. Даатгалын хураамжийн хүүгийн түвшин.

4.4. Хүн амын насжилтын хүснэгт (цаашид “насжилтын хүснэгт” гэх) болон хүн амын нас баралтын түвшин (цаашид “нас баралтын түвшин” гэх)-г Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын насны ангилал, наслалт, нас баралтын олон жилийн статистик судалгаа болон Эрүүл мэндийн хөгжлийн хүрээлэнгээс гаргасан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг судалсан мэдээллийг үндэслэн тогтооно. Хэрэв манай орны насжилтын хүснэгтийг гаргахад мэдээлэл дутагдах тохиолдолд бүс нутгийн ижил төстэй бусад орны насжилтын хүснэгтийг өөрийн нөхцөлд тохируулан ашиглаж болно.

4.5. Насжилтын хүснэгтийг тухайн даатгалын гэрээ байгуулсны дараах 5 жилийн хугацаанд өөрчлөхгүй тогтвортой мөрдөх зарчмыг баримталж боловсруулна.

4.6. Даатгалын цэвэр хураамжийн тооцоонд нас баралтын түвшний өөрчлөлтийг хүйсээр болон бусад төрлийн ангилалаар судлан гаргаж тусгана.

4.7. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг даатгагчаас даатгуулагчид санал болгож байгаа даатгалын хураамжийн баталгаат хүү болон даатгагчийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж олох хүүгийн тооцоолол дээр үндэслэн тогтооно.

4.8. Даатгалын цэвэр хураамжийн хэмжээг тооцоход шаардлагатай бусад судалгааг ашиглаж болно.

4.9. Даатгалын нэмэлт хураамжид дараах зүйлийг оруулж тооцно. Үүнд:

4.9.1. Даатгагчийн үндсэн үйл ажиллагааны зардал;

4.9.2. Даатгагчийн үндсэн бус үйл ажиллагааны зардал;

4.9.3. Давхар даатгалын зардал;

4.9.4. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл;

4.9.5. Даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөр;

4.9.6. Хөрөнгө оруулалттай холбоотой зардал;

4.9.7. Даатгагчийн ашиг (алдагдал);

4.9.8. Бусад зардал.

4.10. Даатгалын нэмэлт хураамжийн хэмжээг тооцоходоо энэ журмын 4.9-д заасан зардал тус бүрээр нарийвчилсан тооцоолол хийнэ.

ТАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ТООЦООЛЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ

5.1. Хороо даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцсон тооцооллыг ажлын 15 хоногийн дотор хянана;

5.2. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоосон материалыг баталгаажуулахад дараах шаардлагыг тавина:

5.2.1. Даатгалын хураамжийн тооцоог эрх бүхий актуарчаар хийлгэх;

5.2.2. Энэ журмын 5.2.1-д заасан судалгаанд ашигласан мэдээллийн бодит үнэнийг холбогдох байгууллагаас авсан баримтаар баталгаажуулсан байх.

5.3. Урт хугацааны даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна.

5.4. Урт хугацааны даатгагч насжилтын хүснэгтийг өөрчлөх тохиолдолд өөрчлөх болсон шаардлага, тооцооллыг боловсруулан эрх бүхий актуарчаар баталгаажуулж Хороонд ирүүлнэ

5.5. Хорооны актуарч урт хугацааны даатгагчаас ирүүлсэн насжилтын хүснэгтийг өөрчлөх болсон шаардлага, ирүүлсэн тооцоолол нь үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлтээ үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

5.6. Урт хугацааны даатгагчнь Хорооноос үндэслэлтэй гэж үзсэн буюу шинэчлэгдсэн насжилтын хүснэгтийг ашиглан хураамжийн болон нөөц сангийн тооцооллыг хийнэ.

5.7. Шинэчлэгдсэн насжилтын хүснэгт нь зөвхөн шинээр байгуулах гэрээний хувьд үйлчилж эхлэх бөгөөд өмнө нь байгуулсан даатгалын гэрээний хураамжид өөрчлөлт орохгүй болно.

ЗУРГАА. БУСАД

6.1. Даатгалын хураамжийн хэмжээг эрсдэлд өртөж болзошгүй объект, өртөх магадлал, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ялгавартай тооцож болно.

6.2. Хоёр жил болон түүнээс дээш хугацаанд гардаг, даатгалын тохиолдол нь олон давтамжтай болдог даатгалын төрлийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тухайн давтамжийн жилийн тоонд хувааж, жилийн даатгалын хураамжийн хэмжээг тооцож болно.

6.3. Эрсдэл тус бүрээр учирч болох хохирлын судалгааг 3-аас доошгүй жилийн статистик мэдээг ашиглаж хийнэ.

6.4. Хороо даатгагчийн сонгосон аргачлалыг шаардлага хангахгүй гэж үзвэл энэ тухай тайлбар, үндэслэлийг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ.

6.5. Энэ журмын 6.4-т заасан тайлбар үндэслэлийн дагуу шаардлага хангасан аргачлал хэрэглээгүй тохиолдолд Хорооноос Даатгалын тухай хуулийн 83.1.32-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--